

АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН 20 ... ОНЫ СУДАЛГАА

1.Хаягийн хэсэг

Дүүргийн нэр:

код

--	--

1. Дүүргийн ЗДТГ нь судалгааг хороо тус бүрээр гаргаж УБ хотын ЗАА-нд 12-р сарын 15-ны дотор, цахим хэлбэрээр хургуулна.
2. УБ хотын ЗАА нь судалгааг хянаж баталгаажуулан 12-р сарын 25-ны дотор НЗДТГ-т цахим хэлбэрээр хургуулна.

2.Мэдээний хэсэг

Хорооны дугаар	Нийт цэгийн тоо	Архи, согтууруулах ундаа худалдаалдаг					Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг			
		Хайпермаркет	Супермаркет	Хүнсний дэлгүүр	Минимаркет	бусад	Ресторан	Баар	Кафе	бусад
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
Дүн										

Бүртгэсэн: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Тамга\тэмдэг
Хянасан: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Маягт ЭАБ-18-ыг нөхөх заавар

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- **01**, Багахангай дүүрэг- **04**, Баянгол дүүрэг- **07**, Баянзүрх дүүрэг- **10**, Налайх дүүрэг- **13**, Сонгинохайрхан дүүрэг- **16**, Сүхбаатар дүүрэг- **19**, Хан-Уул дүүрэг- **22**, Чингэлтэй дүүрэг- **25** гэсэн кодыг зохих нүдэнд бөглөнө. Хорооны дугаарыг "Хүн ам"-ын мэдээллийн санг байгуулах заавраас харж нөхнө. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон www.ubstat.mn цахим хуудсаас энэ кодыг харах боломжтой.

2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

Дүүргийн ЗДТГ нь өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж архи, согтууруулах ундаа худалдаа, үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоог багана 1-д нөхнө. Нийт дүнг дараах тодорхойлолтын дагуу задалж харгалзах баганад хороо тус бүрээр нөхнө. Үүнд:

2-р баганад: "Хайпермаркет" ба агуулахын худалдаа гэж 20000-аас дээш нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний барааг ихэвчлэн жижиглэнгийн үнээр борлуулж үйлчилдэг, хэрэглэгчийн хэрэгцээг нэг цэгээс хангахаар төлөвлөн зохион байгуулсан үйлчилгээний газрыг;

3-р баганад: "Супермаркет" гэж 10000 хүртэл нэр төрлийн хүнсний болон өдөр тутмын хэрэглээний ариун цэвэр, гоо сайхны бараа, гэр ахуйн бараа, бүтээгдэхүүний төрөлжсөн тасгуудтай, өөртөө үйлчлэх дэлгүүрийг;

4-р баганад: "Дэлгүүр" гэж уламжлалт лангууны зохион байгуулалттай, өдөр тутмын болон өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн жижиглэнгийн үнээр борлуулдаг газрыг;

5-р баганад: "Минимаркет" гэж сав баглаа, боодол бүхий өргөн хэрэглээний барааг жижиглэнгийн үнээр худалдаалдаг, өөртөө үйлчлэх лангуу бүхий газрыг;

6-р баганад: Багана 2, 3, 4, 5-д дурьдаагүй архи, согтууруулах ундаа худалдаалдаг цэгийн тоог нөхнө.

7-р баганад: "Ресторан" гэж нарийн ажиллагаа шаардах олон нэр төрлийн хоол ундаа, түүний дотор нэршсэн болон захиалгат хоол үйлдвэрлэж, хэрэглэгчийн тав тухтай амарч, хооллох нөхцлийг хангасан дээд зэргийн үйлчилгээ зохион байгуулдаг хоолны газрыг;

8-р баганад: "Баар" гэж нум хэлбэрийн өндөр лангуу, түүндээ тохирсон босоо сандал, ханын гоёмсог шүүгээ, тавиур, гэрэлтүүлэг, хундага жүнз өлгөх дэгээ, хоногтой дүүжин тааз, үйлчилгээний тохилог танхим, тусгай кабин, сандал буйдан, хөгжим болон гэрэлтүүлгийн төхөөрөмж, хэрэгсэл бүхий хоолны газрыг болон караоке баарыг;

9-р баганад: "Кафе" гэж хэрэглэгчдийн амралт чөлөөт цагаа тав тухтай өнгөрүүлэхэд зориулагдсан хоолны газар бөгөөд үйлдвэрлэж борлуулах хоол, зуушны нэр төрөл харьцангуй хязгаарлагдмал гол төлөв төрөлжсөн болон захиалгат хоол зууш, гурилан бүтээгдэхүүн, төрөл бүрийн ундаа, ялангуяа цай кофе, хөөрүүлсэн сүү, халуун шоколад гэх мэт халуун ундааны зүйлээр үйлчилдэг газрыг оруулна.

10-р баганад: Багана 7, 8, 9-д дурьдаагүй архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгийн тоог нөхнө.

Нийслэлийн ЗАА нь дүүргийн ЗДТГ-аас ирүүлсэн тайланг холбогдох хууль тогтоомж, олгосон зөвшөөрөл зэрэгтэй уялдуулан хянан шалгаж, баталгаажуулан Нийслэлийн ЗДТГ-т хугацаанд нь өгнө.